

ТҮРЭГ ХЭЛНИЙ ЯЗГУУР ҮНДСИЙН ХУВИЛБАР БА ТҮРЭГ ХЭЛНЭЭС МОНГОЛ
ХЭЛНЭЭ ОРСОН ХОЁР ҮГИЙН ТУХАЙ

Т. Цэцэгжаргал, М.Ууганбаяр¹

Түрэг хэлний зарим үгийн хувилбарууд монгол хэлнээ өөр өөр эх сурвалжаас орж ирдэг бөгөөд бид энэ удаа монгол хэлний **бий**, **бүжиг** гэсэн үгийн жишээгээр энэхүү үзэгдлийг авч ярья.

Түрэг хэлний **бий** /bij бийн-/biji- хэмээх үгийг гарлын үүднээс судалсан Э.В. Севортян өөрийн толиндоо:

I **бий** /bij кир., ккал.: **би**/bi кум., каз.;

II **бийн-/biji-** кум., ног., KW₅₇, Мел. АФ₀₈₄ (в сос гаве **бичи**, **бийичи** ‘бүжигч’ –ийн бүрэлдэхүүнд), Ibnū B=M.₂₁; **бийн-/biji-** тат., P IV₁₇₉₀ (казан.), **бийн-/biji-** баш.: **бо-** P IV₁₇₃₇ (куман.) **бүди-/būdi-** ДТС₁₈₁ (ТТХ_{145,469}), Gab. II₁₃₃ ТТХ₄₃, Lig. VSOu₁₄₇; **бүзи-/būdi-** ДТС₁₈₁ (МК III 259), Brock₁₄₆, Kvdg. D.₁₂₂; **būti-** ДТС₁₃₄; **бүйн-/būji-** каз. диал. КТДС₇₅; **beji-** KW₅₄;

III ***bi-** (**бигиш** ‘бүжигч’ –ийн бүрэлдэхүүнд) P IV₁₇₄₂ (кир.=каз.), **би** Мел. АФ₀₈₃ **bai-Houts**₆₀;

IV ***piiie** /rije (**пийеле-** ‘бүжиж’, ‘бүжиглэх’ –ийн бүрэлдэхүүнд) алт. ГАЯ₁₁₇, P IV₁₃₂₉ (алт., леб); **бид’e/bid’e** алт.: **битн:/biti:** як.

МА₁₂₃ д **bijidi** тэр **бүжиглэв** гэсэн үйл үг гарах ба түүнчлэн(415 х) энэхүү дурсгалын хэвлүүлэгч **biḅdi** хэмэн засах хэрэгтэй хэмээн гэмдэглэж байна. Түүнчлэн татар аялгуунуудад байх **biḅi-** монгол хэлнээс зээлсэн “бүжих” хэмэх зээллэг үгтэй харьцуулна уу (ДСТ₈₃).

I 1. **Бүжиг** –бүх дурсгал бичгүүдэд;

II 1. **Бүжиглэх, бүжих-** бүх дурсгал бичгүүдэд

2. Гар хөлөөрөө хэмнэлтэй яруу хөдлөх ТТХ:

3. Гарлын хувьд шилжсэн утга “долигонох бөхөлзөх” —баш.;

III * **бүжиглэх бүжих;**

IV 1. **Бүжиг** —алт., як., Буд.: **бүжиг**—алт., як., P I₁₃₂₉ (алт., леб.);

2. нэг газар дэвхцэх, үсрэх—як.;

3. агаарт нисэн халих дүүлэх чичрэх /шувууны/—як.

- Хуучны бичвэрүүд дэхь язгуурын эгшийг Ж. Клосон монгол хэлнээ тулгуурлаад **-ө-** хэмээн уншсан. (СI_{300b}, түүнчлэн СI_{303b}, 309b г харна уу). Гэвч сүүлийн бичвэрт **bozig**, мөн **byzig** /**бүжиг** ‘бүжиг’, ‘театрын үзүүлбэр’, ‘тоглоом’ (Less._{129, 153}) гэж байгаа ба . М.Кашгарийн «Диван» д бичигдсэн баримтыг **-ү-** болон **-ө-** тэйгээр мөн уншиж болно;

1. Монгол Улсын Их Сургууль

- **biji-, bij, būdi-** гэх мэт хэлбэр утгын жагсаалтыг Ras. VEWT^{91a} д үзнэ үү. Г.Рамстедт монг. **°bōzi-/būzi-** (**byzi-** /бүжих Less.¹⁵³ тая харьцуулна үү) ‘бүжиглэх’ ийг адил утгатай як. **bitii-**, кир. **bij-** тай харьцуулсан (Ram. KWb.⁵⁴). Тэрбээр Халм. **bo** ‘бүжиг/ийг’ кир. **bijū, bijiw** “бүжиг”ээс танец’ (стр.47) ээс, **bilxe-** ‘бүжиглэх’ хэмээх үйл үгийг тюрк. **bij-, bijil-** гэх нэгэн адил утгатай үгээс гаралтай гэжээ. (мөн тэнд). Г. Рамстедт өөрийн сүүлийн үеийн солногс хэлний гарлын судалгаандаа дээрх эгнээнд хятад солонгос хэлний **mū-** ‘бүжиг’-ийг монгол хэлний **būzi-** (***bū-di-**) ‘танцевать’ үгийн ***bū** язгуур гэж үзэж байв (Ram. SKE¹⁵²).” гэж бичжээ. /Севортян 1978:52/

Ойрд нутгийн аялгууны толиноос харахад **бий** хэмээх энэ үг дөрвөд, захчин, торгууд, өөлд, баяд, хотон аман аялгуу, халимаг хэлнээ **bi** “бий бүжиг ардын бүжиг” **bi bilixxe biilatsi bitsi** “бийлээч бийч” **bilikxe biyelexxe** “биелэх ардын бүжиг бүжих”, монгол болон тод бичгээр **beyeleku** / Цолоо 1988:101/ гэсэн байдалтай байна.

Эртний түрэг толиноо **būdik** бүжиг /Махмуд Кашгарийн толь МК I 412/ **seviné kōrsa šta ojun ja budik** хэрвээ хэн нэгэн зүүдэндээ хөөр баяр тоглоом бүжгийг үзвэл/Күтадгү Билик QBN 431₆/ гээд **budik** хэмээх хувилбар байдгийг дурджээ /ДТС:131/

М.Базаррагчаа **бө-жи-кү бү-жи-кү** “бөөрөнхий юм эргэлдэн хөдлөх” гээд болсон нь бөөрөнхий юм өнхрөх бус нарийн цэмцгэр юм уртай хөдлөх гэсэн утга илтгэхтэй холбоотой гэсэн нь сонирхолтой юм /Базаррагчаа 1994:331-334/.

Бидний хувьд Г. И. Рамстедтийн монгол хэлний **bōzi-/būzi- byzi-** /бүжих ‘бүжиглэх’ ийг адил утгатай якүт хэлний **bitii-**, кир. **bij-** тай харьцуулсан хийгээд халимаг хэлний Халм. **bo** ‘бүжиг/ийг’ киргиз хэлний **bijū, bijiw** “бүжиг”ээс болон халимаг хэлний **bilxe-** ‘бүжиглэх’ хэмээх үйл үгийг түрэг хэлний. **bij-, bijil-** гэх нэгэн адил утгатай үгээс гаралтай /Ramstedt 1935:54/ гэсэн санал зөв бөгөөд Э. В. Севортяны үзүүлсэн баримтаас харвал киргиз, каракалпак хэлний **бий/bij** күмык казах хэлний **би/bi** хэмээх үг хийгээд эртний түрэг хэлний **бүди-/būdi- бүзи-/būdi-** хоёр үг нь утгаа түрэг хэлний нэг язгуур үндсийн хоёр өөр хэлбэр байна. Эртний түрэг хэлний энэхүү **бүди-/būdi- бүзи-/būdi-** язгуурын авианы өөрчлөлтөөс үүссэн орчин үеийн киргиз, каракалпак, **бий/bij** хувилбар монгол хэлний ойрд аялгуу, халимаг хэлнээ **bi** гэсэн хэлбэрээр тархсан ажээ. Өөрөөр хэлбэл, түрэг хэлний үг бүтэх ёсны үүднээс үг бүтээх үндэс буюу Э. В. Севортяны үзүүлсэн киргиз каракалпак зэрэг хэлний **бийн-/biji-** үйл үндэс нь утгаа эртний түрэг хэлнээ **бүди-/būdi- бүзи-/būdi-** хэлбэртэй байснаас үгийн үндсийн сүүлийн **di** хэмээх хэсэг **-ji** болж хувирсан хэлбэр бөгөөд одоо цагт киргиз каракалпак хэлнээ **бий/bij** гэсэн бас нэг хувилбар үг бүжиг гэсэн утгатай болсон нь, эртний түрэг хэлний **бүди-/būdi- бүзи-/būdi-** язгуураас үүссэн **būdik budik** “бүжиг” гэх үг нь монгол хэлнээ **būjig** хэмээх үг болсон байхад харин энэхүү эртний түрэг язгуур, үндсээс киргиз каракалпак хэлнээ үлдсэн нэг нэрийн хувилбар **бий/bij** буюу бүжиг гэх үг, ойрд нутгийн аялгуу, тухайлбал, дөрвөд захчин торгууд өөлд баяд хотон аман аялгуу халимаг хэлнээ **bi** “бий бүжиг ардын бүжиг”, **bi bilixxe biilatsi bitsi** “бийлээч” гэсэн үг болсноороо түрэг хэлний үг бүтээх загварыг үзүүлж байгаа жишээ тул бидний бодоход, монгол хэлний **бүжиг** хэмээх үг эртний түрэг хэлнээс, монгол хэлний **бий** хэмээх үг орчин цагийн киргиз, каракалпак зэрэг хэлнээс монгол хэлний баруун аялгуунаа зээлэгдсэн үг бололтой байна. Түрэг хэлнээс монгол хэлнээ орсон үгийг тогтооход юуны өмнө түрэг үг авианы дүр төрхийн болоод утгын хувьд таарч байх, үгзүйн шинж нь түрэг онцлогтой байх гэсэн шинж, цаашлаад түрэг үг зарим нэгэн монгол хэл аялгуунд дэлгэрсэн байх, түрэг хэлнээс зээлсэн үгийн утга явцуурах, зөвхөн нэг утга нь монгол хэлэнд илрэх зэрэг хэмжүүрээр харвал /Рассадин 2007:25/ **бий** хэмээх монгол үг киргиз каракалпак зэрэг хэлний жишээтэй авианы дүр төрх утгын хувьд таарч байгаа мөн, энэ үг түрэг хэлний үгзүйн шинжийг илтгэж буйг Э. В. Севортяны дээр иш татсан судалгаа харуулж байгаа хийгээд, **бий** хэмээх үг зөвхөн ойрд аялгуу, халимаг хэлнээ хадгалагдсан, түрэг хэлний бүжиг гэсэн өргөн

утга явцуурч монгол хэлнээ зөвхөн ардын бүжиг гэсэн утгыг агуулдаг нь монгол хэлний **бий** хэмээх үгийн түрэг гаралтай болохын хангалттай нотолгоо гэж үзэж болно. Түүнчлэн монгол хэлний **бүжиг** хэмээх үг эртний түрэг хэлний **būdik buđik** “бүжиг”- ээс зээлэгдсэн гэдгийг мөн л эртний түрэг хэлний дурсгалын баримт, түрэг хэлний талаас энэхүү үг олон хувилбартай нэр үйлийн үндэс үүссэн үг бүтэх ёсны шинж, түрэг хэлнээ **būdik buđik** хэмээх үг нь өөрөө хувирч киргиз каракалпак хэлнээ **бий/bij** гэсэн бас нэг хувилбар үг үүссэн үгзүй гарал зүйн шинж баталж байна.

НОМ ЗҮЙ

Базаррагчаа М Монгол үгийн гарлыг мөшгих нь IV Улаанбаатар 1994

Древнетюркский словарь. Редакторы В.М.Наделяев, Д.М.Насилов, Э.Р.Тенишев, А.М.Щербак. Л.: «Наука». Ленинградское отделение. 1969.

Рассадин В.И. Очерки по истории сложения тюрко-монгольской языковой общности часть I Тюркское влияние на лексику монгольских языков. Элиста, 2007

Севортян, Э.В. Этимологический словарь тюркских языков:Общетюркские и межтюркские основы на букву”Б” /АН СССР.Ин-т языкознания.-М.:Наука.1978

Цолоо Ж. БНМАУ дахь нутгийн аялгууны толь бичиг II Улаанбаатар 1988

Ramstedt G.J. Kalmukisches Worterbuch. Helsinki. 1935

Summary

According to our research Mongolian dance terms as *biy bujig* become Turkish loan words.

Kyrgyz and Karakhalpakh **biji** – and ancient Turkish **бүди-/būdi-** **бүзи-/būdi-** forms originate as variants from common verb *steem* in Turkish. In Mongolian the word *bujig* becomes borrowing form from Ancient Turkish and the word *bij bi* becomes borrowing form Kyrgyz and Karakhalpakh.